



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/816

Булган сум

Сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарын  
2025 оны хамтран ажиллах гэрээг  
дүгнэсэн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.5 дахь хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга, тосгоны Захирагчийн 2025 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг дүгнэсэн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2. Хамтран ажиллах гэрээний үнэлгээг үндэслэн сахилгын шийтгэлтэйгээс бусад сумын Засаг дарга, тосгоны Захирагчид холбогдох журмын дагуу урамшуулал олгохыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Хамтран ажиллах гэрээ дүгнэсэн байдалд дүн шинжилгээ хийж, 2026 оны хамтран ажиллах гэрээг оны эхнээс заалт нэг бүрээр хяналтад авч биелэлтийг тооцож тайлагнахыг сумын Засаг дарга нар, тосгоны Захирагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

0225011247

Аймгийн Засаг даргын 2025 оны  
D дугаар сарын 25-ны/ний өдрийн  
A.1816 б. дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА,  
ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН 2025 ОНД БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ  
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

| д/д | Сум, тосгоны нэрс | Үнэлгээ хувиар |
|-----|-------------------|----------------|
| 1   | 2                 | 3              |
| 1   | Баян-Агт сум      | 76.1           |
| 2   | Баяннуур сум      | 75.8           |
| 3   | Бугат сум         | 73.2           |
| 4   | Булган сум        | 84.2           |
| 5   | Бүрэгхангай сум   | 80.5           |
| 6   | Гурванбулаг сум   | 85.1           |
| 7   | Дашинчилэн сум    | 79.4           |
| 8   | Могод сум         | 78.6           |
| 9   | Орхон сум         | 75.8           |
| 10  | Рашаант сум       | 79.9           |
| 11  | Сайхан сум        | 70.0           |
| 12  | Сэлэнгэ сум       | 82.1           |
| 13  | Тэшиг сум         | 76.4           |
| 14  | Хангал сум        | 76.3           |
| 15  | Хишиг-Өндөр сум   | 79.8           |
| 16  | Хутаг-Өндөр сум   | 84.5           |
| 17  | Хялганат тосгон   | 80.0           |

--о00о--